



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/161/СТА/ШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮ, 7
ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАВААЖАРГАЛ
ТАНАА

2021.02.25 № 2/89

танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** 7

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Санхүү, хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Санхүү, хяналт, дотоод аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

2021 A4 TOOT

• 005029058

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Засаг дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймгийн Санхүү, хяналт, аудитын албаны дарга тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,517,800.00</u>	<u>3,799,800.00</u>
33	АВЛАГА	140,000.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	140,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,377,800.00	3,799,800.00
354	Хангамжийн материал	2,377,800.00	3,799,800.00
35410	Бичиг хэргийн материал	623,000.00	872,000.00
35420	Аж ахуйн материал	1,754,800.00	2,927,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,301,446.45</u>	<u>9,408,172.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,301,446.45	9,408,172.58
392	Биет хөрөнгө	3,301,446.45	9,408,172.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,991,319.50	10,991,319.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,701,461.35	-10,991,319.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,375,220.00	26,964,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	20,034,734.29	-21,025,170.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,999,820.00	10,239,820.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,378,617.41	-6,821,097.42
39217	Ном	49,900.00	49,900.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,819,246.45</u>	<u>13,207,972.58</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,819,246.45</u>	<u>13,207,972.58</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,819,246.45	13,207,972.58
512	Хуримтлагдсан үр дүн	5,819,246.45	13,207,972.58
51210	Өмнөх үеийн үр дүн	15,958,078.55	5,819,246.45
51220	Тайлант үеийн үр дүн	10,138,832.10	7,388,726.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,819,246.45</u>	<u>13,207,972.58</u>

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	145,023,600.00	170,493,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	8,602,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,602,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,602,500.00

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	8,602,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,023,600.00	161,891,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,023,600.00	156,891,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,023,600.00	156,891,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	155,162,432.10	163,105,173.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,162,432.10	163,105,173.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	152,201,398.10	156,012,210.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,519,600.00	114,766,809.44
210101	Үндсэн цалин	83,405,170.00	100,516,009.44
210102	Нэмэгдэл	54,109.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,060,321.00	6,057,565.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	8,193,235.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,835,065.00	14,447,200.00
210201	Тэтгэврийн даатгал	6,904,965.00	9,824,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	982,500.00	1,155,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	786,000.00	924,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	196,500.00	231,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,965,100.00	2,311,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,089,049.00	11,065,335.00
210401	Бичиг хэрэг	2,496,300.00	2,836,340.00
210402	Тээвэр, шатахуун	8,409,600.00	7,009,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,183,149.00	1,219,395.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,613,100.00	1,874,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,783,100.00	1,874,000.00
210604	Урсгал засвар	1,830,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	14,918,500.00	8,410,000.00
210702	Дотоод албан томилолт	14,918,500.00	8,410,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,609,922.00	681,592.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,310,000.00	382,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	149,922.00	149,092.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.00	130,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,416,162.10	4,567,273.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,385,000.00	844,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,031,162.10	3,722,773.87

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,961,034.00	7,092,963.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,931,566.00	6,913,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,931,566.00	6,913,750.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,468.00	179,213.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,468.00	179,213.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,138,832.10	7,388,726.13
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-10,138,832.10	7,388,726.13

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	145,023,600.00	161,891,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,023,600.00	161,891,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	145,023,600.00	156,891,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	145,023,600.00	156,891,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	143,723,700.00	160,491,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143,723,700.00	160,491,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,762,666.00	153,398,436.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,254,200.00	114,626,809.44
210101	Үндсэн цалин	83,580,600.00	100,376,009.44
210102	Нэмэгдэл	54,109.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,619,491.00	6,057,565.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	8,193,235.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,275,895.00	14,447,200.00
210201	Тэтгэврийн даатгал	8,345,795.00	9,824,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	982,500.00	1,155,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	786,000.00	924,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	196,500.00	231,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,965,100.00	2,311,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,214,049.00	10,804,335.00
210401	Бичиг хэрэг	2,621,300.00	2,101,210.00
210402	Тээвэр, шатахуун	8,409,600.00	7,009,600.00

**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,183,149.00	1,502,395.00
210404	Ном, хэвлэл	00.00	191,130.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	1,200,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,905,100.00	1,874,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,373,100.00	1,874,000.00
210602	Тавилга	237,400.00	00.00
210604	Урсгал засвар	1,294,600.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	14,918,500.00	8,410,000.00
210702	Дотоод албан томилолт	14,918,500.00	8,410,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,609,922.00	681,592.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,310,000.00	382,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	149,922.00	149,092.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.00	130,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,385,000.00	1,354,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,385,000.00	1,354,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,961,034.00	7,092,963.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,931,566.00	6,913,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,931,566.00	6,913,750.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,468.00	179,213.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,468.00	179,213.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,299,900.00	1,400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,299,900.00	1,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,299,900.00	1,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,299,900.00	1,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,299,900.00	1,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,299,900.00	-1,400,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,958,078.55	15,958,078.55
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,958,078.55	15,958,078.55
C07	Тайлант үеийн үр дүн	-10,138,832.10	-10,138,832.10
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,819,246.45	5,819,246.45
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,819,246.45	5,819,246.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,819,246.45	5,819,246.45
D08	Тайлант үеийн үр дүн	7,388,726.13	7,388,726.13
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,207,972.58	13,207,972.58

2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156,891,400.00	156,712,186.44	179,213.6	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,891,400.00	156,712,186.44	179,213.6	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,891,400.00	154,798,436.44	92,963.6	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,637,400.00	114,626,809.44	10,590.6	100.0
210101	Үндсэн цалин	100,386,600.00	100,376,009.44	10,590.6	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,144,700.00	6,144,700.00	0.0	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	8,106,100.00	8,106,100.00	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,447,200.00	14,447,200.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	9,824,100.00	9,824,100.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,155,800.00	1,155,800.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	924,600.00	924,600.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	231,200.00	231,200.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,311,500.00	2,311,500.00	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,823,400.00	10,804,335.00	19,065.0	99.8

**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	2,107,100.00	2,101,210.00	5,890.0	99.7
210402	Тээвэр, шатахуун	7,009,600.00	7,009,600.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,514,700.00	1,502,395.00	12,305.0	99.2
210404	Ном, хэвлэл	192,000.00	191,130.00	870.0	99.5
210502	Хоол, хүнс	200,000.00	200,000.00	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,283,400.00	3,274,000.00	9,400.0	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,883,400.00	1,874,000.00	9,400.0	99.5
210602	Тавилга	1,400,000.00	1,400,000.00	0.0	100.0
2107	Томилот, зочны зардал	8,463,000.00	8,410,000.00	53,000.0	99.4
210702	Дотоод албан томилот	8,463,000.00	8,410,000.00	53,000.0	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	682,500.00	681,592.00	908.0	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	382,500.00	382,500.00	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	149,092.00	908.0	99.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,000.00	130,000.00	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1354500.00	1354500.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,354,500.00	1,354,500.00	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	1913750.00	86,250.0	95.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,913,750.00	86,250.0	95.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,913,750.00	86,250.0	95.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	156,891,400.00	156,712,186.44	179,213.6	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	156,891,400.00	156,712,186.44	179,213.6	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	156,891,400.00	156,712,186.44	179,213.6	99.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9	9	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	2	2	0.0	100.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваажаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 сарын 08-аас 2021 оны 02 сарын 10-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.10.28-ны өдрийн 120 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны эрхэм зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, аудит хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь тайлант онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

- Хууль тогтоомж, гэрээ, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, төсвийн санхүүжилт түүний үр дүн, санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, эрсдэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулах.
- Төсвийн тухай хуулийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны 3 дугаар улирлын нийт зардлын 111852.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2237.0 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 163105.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 3262.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Санхүү, хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 13208.0 мянга өмнөх оноос 7388.7 мянган төгрөгөөр буюу 123 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,517.8	3,799.8	1,282.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	140.0	-	(140.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,377.8	3,799.8	1,422.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,301.4	9,408.2	6,106.7
Үндсэн хөрөнгө	39,296.3	49,125.8	9,829.5

**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хуримтлагдсан элэгдэл	(35,994.8)	(39,717.6)	(3,722.8)
Нийт хөрөнгө	5,819.2	13,208.0	7,388.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,819.2	13,208.0	7,388.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,819.2	13,208.0	7,388.7

Авлага данс нь оны эхэнд ажиллагсдаас авах авлага 140.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант хугацаанд байгууллагын дансанд тушааж үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3799.8 мянган төгрөг болж 1422.0 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 249.0 мянга, аж ахуйн материал 1173.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Энэ нь тайлант хугацаанд бичиг хэрэг болон аж ахуйн материалын зардлыг нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 49125.8 мянган төгрөг болж 9829.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.12.21-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор Орон нутгийн өмчийн газраас 3589.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг балансаас баланст шилжүүлэн авсан, 4839.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 1400.0 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13208.0 мянган төгрөг болж 7388.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 170493.9 мянган төгрөг болж өмнөх оноос 25407.3 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 25407.3 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь орон нутгийн төсвөөс авах санхүүжилт 11867.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 8602.5 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс төрийн албан хаагчийн орон сууц, хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд 5000.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардал 163105.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7942.7 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 205607.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 205607.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 39794.8 мянган төгрөгөөр бууруулж 165813.0 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь цалин, НДШ, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулж баталсантай холбоотой байна.

Тайлант онд анх баталсан 165813.0 мянган төгрөг ба тодотголоор 8921.6 мянган төгрөгөөр бууруулж 156891.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь цалин, НДШ, хангамж бараа материалын зардал, томилолтын зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлуудыг хасаж, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, нэг удаагийн тэтгэм урамшууллын зардлыг нэмж тодотгосонтой холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 156891.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 156891.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 156891.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 156712,2 мянган төгрөгийг зарцуулж, 179.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 156712.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 10.6 мянга, хангамж, бараа материалын зардал 19.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 9.4 мянга, томилолт, зочны зардал 53.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 53.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 9 мэдээлэл байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан

бараа, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, тухайн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт тайлан, дүгнэлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг орлогын 1 гүйлгээний 16564.4 мянга, зарлагын 1 гүйлгээний 5000.0 мянган төгрөгийн мэдээллүүдийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9			2
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	88	8		
6	Нийт	27	151	140	9		2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудит хийгдээгүй “Итгэл” үзүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11093.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1500.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 9593.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1500.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

1.Тайлант хугацаанд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1000.0 мянган төгрөг батлагдсан ба албан хаагчдад 125.0 мянган төгрөгийн өртөгтэй 8 ширхэг хувцас авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 55 тушаалын Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд “Хуулийн дагуу тусгай дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий албан хаагчдын дүрэмт хувцас болон ажлын тусгай зориулалтын нормын хувцас

худалдан авах, түүнийг хийлгэхтэй холбогдсон үндсэн болон, туслах материал болон бусад зардал, эмнэлэг, сургуулийн дотуур байр, цэргийн болон бусад байгууллагын хэрэгцээнд ашиглах ор, дэрний хэрэгсэл болон бусад зөөлөн эдлэлийг бүртгэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 1000.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тухайн байгууллагын харилцахаар дансаар гарсан гүйлгээг анхан шатны баримттай нь тулган шалгаж үзэхэд 2020.02.10-ны өдөр “РМБ” ХХК руу сургалтын зардал 500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Зориулалт бусаар зарцуулсан 500.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Цаашид анхан шатны баримт бүрдэлгүй зардал гаргаж байгаа, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд хоолны хөнгөлөлт урамшууллын зардалд 6144.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан ба эхний 1-10 сард 7135.0 мянган төгрөг олгосон бөгөөд Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2020.11.02-ны өдрийн 26 дугаар тушаалаар хоолны мөнгийг өдөрт 20.0 мянган төгрөг байхаар тогтоож 11 сард 9 хүнд 2071.0 мянга, 12 сард 9 хүнд 4726.7 мянган төгрөгийг олгож цалингийн батлагдсан төсвийг дотор нь тус зардалд 7788.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2."Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

1.3 Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж, цалингийн зардлыг /үндсэн цалин болон хоол унааны хөнгөлөлт/ гүйлгэн зарцуулдаг явдлыг таслан зогсоох.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд тээвэр шатахууны зардалд 7009.6 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 7009.6 мянган төгрөгийн зарцуулсан байна. Шатахууны зарцуулалтыг нярвын тайлан, жолоочийн замын хуудастай тулган шалгахад 1-8 сард жолоочийн тооцооны хуудаст шатахууны зарцуулалтыг тооцохдоо спидометрийн заалтыг үндэслэн нягтлан бодогч тооцоо бодоогүй байна. Мөн тухайн албаны дарга нь дуудсан албан бичиг, явсан ажлын талаар тайлан байхгүй 1-5 сард 4 удаа Улаанбаатар хот руу 1805.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна..

2.2. Эрсдэл

Тээвэр шатахуун зардлыг батлагдсан төсвөөс үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулах

2.3 Өгсөн зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 1805.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тайлан гаргаж холбогдох материалыг ирүүлэх ба цаашид жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог бодохдоо тухай бүр автомашины явсан замын тооцооны хуудсыг спидометрийн заалттай тулгаж, бичилт хийн бүртгэлд тусгаж байх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 9 мэдээлэл байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр хураамж, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, тухайн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт тайлан, дүгнэлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг орлогын 1 гүйлгээний 16564.4 мянга, зарлагын 1 гүйлгээний 5000.0 мянган төгрөгийн мэдээллүүдийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.2. Эрсдэл

Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

3.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу дээрх хугацаа хоцроож байршуулсан мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.5. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН
ОГНОО: 2021.02.25

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.25

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.25

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/161/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Санхүү, хяналт аудитын газар	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант хугацаанд нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 1000.0 мянган төгрөг батлагдсан ба байцаагч аудитор нарт 125.0 мянган төгрөгийн өртөгтэй 8 ширхэг хувцас авсан байна.	1000.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга нягтлан бодогч	Д.Даваажаргал Б.Бат-Эрдэнэ
2	2020.02.10-ны өдөр "РМБ" ХХК руу сургалтын зардал 500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр шилжүүлсэн байна.	500.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга нягтлан бодогч	Д.Даваажаргал Б.Бат-Эрдэнэ
3	Үндсэн цалингаас хоол унааны нэмэгдэлд 7788.0 мянган төгрөгийн гүйлгэн зарцуулсан байна.	7788.0	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Д.Даваажаргал Б.Бат-Эрдэнэ
4	Нягтлан бодогч тээвэр шатахууны зардлыг тооцоог бодохдоо спидометрийн заалтын үндэслэн тооцоог бодоогүй, албаны дарга Улаанбаатар руу эрх бүхий албан тушаалтны томилсон томиллолт болон явсан ажлын талаар тайлан байхгүй 1-5 сард 4 удаа 1805.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан байна	1805.0	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Д.Даваажаргал Б.Бат-Эрдэнэ
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 9 мэдээлэл байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Д.Даваажаргал Б.Бат-Эрдэнэ
ДҮН		11093.0			